



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 4/215

Эрдэнэт

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “в”, 29.1.6 “б”, 29.1.6 “л”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 31 дүгээр тушаал, 2021 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын батлагдсан тохиолдлын тоо эрс нэмэгдэж эмнэлгийн байгууллагын тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, орны тоо хүрэлцэхгүй байгаатай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал, амралтын газар, зочид буудал, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутны байр, спорт заал, хоол үйлдвэрлэлийн газар болон тэдгээрийн хүн хүч, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг коронавируст халдвартын батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх зориулалтаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дайчлан ашиглах, татан оролцуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох таоцоо судалгааг гаргаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг өдөр бүр Улсын Онцгой комиссын Шуурхай штабт танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч М.Түмэнжаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2021 оны
04 дүгээр сарын 20-ны өдрийн
2021 дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДӨХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: М.Түмэнжаргал (Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд: Б.Эрдэнэбаяр (Онцгой байдлын газрын гамшигаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)
- Б.Билэгсайхан (Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч)
- Д.Оюунтунгалааг (Мэргжлийн хяналтын газрын эмчилгээ, чанар хяналтын улсын байгцаагч)
- Д.Дашням (Боловсрол соёл урлагийн газрын ахлах мэргэжилтэн)
- О.Энхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн Төсвийн төлөвлөлт, зарлага хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Н.Чулуун-Эрдэнэ (Эрүүл мэндийн газрын өрөнхий нягтлан бодогч)
- Г.Батдэлгэр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга)
- Д.Мөнхболд (Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга)
- С.Сэрээтэрдорж (Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Зохион байгуулалт, баг хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Т.Энхжаргал (Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
- Нарийн бичгийн дарга: Б.Уртнасан (Эрүүл мэндийн газрын гамшиг яаралтай тусlamж хариуцсан мэргэжилтэн)

OO